

Холбоо үг

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Үгс өөр хоорондоо нөхцөлөөр болон үндсээрээ шууд холбогдон холбоо үг бүтээнэ. Ж нь: ах, шугам гэсэн хоёр үг харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр холбогдож, “ахын шугам” гэсэн холбоо үг бүтэж байна. Харин зузаан, ном гэсэн хоёр үг ямар нэг нөхцөлгүйгээр шууд холбогдож “зузаан ном” гэсэн холбоо үгийг бүтээж байна. Ийм холбоо үгийг үндсээр холбогдсон холбоо үг гэнэ.

Дасгал 22. Холбоо үгийн үүргийг ойлгоорой.

Алхам 1. Үгсийг зөв байрлуулан, өгүүлбэр бүтээгээрэй.

Үгс: урамшуулж, өдөр, өөрийгөө, бай, бүр

Өгүүлбэр:

Үгс: далны, цээрлэнэ, илэхийг, ганцаараа, хуулгыг

Өгүүлбэр:

Үгс: энэ, дуу эхийн, уяхан, хамгийн, хорвоод, бүүвэйн

Өгүүлбэр:

Үгс: үнэн, бай, бусдад, сэтгэлээсээ, баярлаж

Өгүүлбэр:

Үгс: : Аажуухан, өдрийн, наран, улаан, говьд, зуны, урт том, жаргалаа.

Өгүүлбэр
Алхам 2. Цэгийн оронд тохирох нөхцөл нөхөж, өгүүлбэрийг гүйцээгээрэй.

Хурдаа хассан нь

Багш: - Хүү минь яагаад хичээл.....ээ хоцор..... бэ?

Хүү: - Зам..... хажууг..... тэмдэг бол..... хоцорчихлоо.

Багш: - Зам..... хажууг..... тэмдэг чи..... хоцор.....д ямар буруу..... юм бэ?

Хүү: - Сургуул..... бүс! Хурдаа хас..... уу гэ..... бай..... шүү дээ.

Алхам 3: Дараах өгүүлбэрийн доторх үгсийн холбоог зурж тэмдэглээрэй

Үнхэлцээ хагартал айсан нь

Хүү: - Оливын тосыг юугаар хийдэг юм бэ? Ээж ээ!

Ээж: -Оливоор л хийнэ.

Хүү: - Тэгвэл хүүхдийн тосыг юугаар хийдэг юм бэ? Яана аа!!

Алхам 4. Өгүүлбэр доторх үгсийн холбоог тайлбарлаарай.

Хүү: - Өвөө та шүдтэй юу?

Өвөө: - Байхгүй.

Хүү: - Аан, та тэгвэл миний бэлгийг хадгалж байгаарай. Би гадаа тоглож байгаад ирье.

1. Өгүүлбэр бүтээж буй үгсэд асуулт тавиарай.	Хэн? Юутай юу? Та шүдтэй юу?
2. Холбоо үгээр задалж бичээрэй.	та шүдтэй, шүдтэй юу
3. Ямар хэрэглүүрээр холбогдсоныг тайлбарлаарай.	“Та шүдтэй” гэсэн холбоо үг нь нэрлэхийн тийн ялгалын тэг нөхцөлөөр холбогдож, холбоо үг бүтээж байна. Шүдтэй юу” хэмээх холбоо үг нь хамтрахын тийн ялгалын –тай нөхцөлөөр холбогдож, холбоо үг бүтээж байна.

1. Өгүүлбэр бүтээж буй үгсэд асуулт тавиарай.	1. 2. Та миний бэлгийг хадгалж байгаарай.
1. Холбоо үгээр задалж бичээрэй.	1. 2.
1. Ямар хэрэглүүрээр холбогдсоныг тайлбарлаарай.	1.

Алхам 5. Дараах холбоо үгсээр өгүүлбэр бүтээгээрэй

Зүүдэлсэн нь

Хүү маань босоод, өглөө босоод, би зүүдэлсэн, урд шөнө, урд шөнө зүүдэлсэн, зүүдэлсэн гээд, ээждээ ярьж, ярьж өгч байна.

.....
.....
.....

Тэгэхээр нь асуусан чинь, үргэлжлүүлээд асуусан чинь, “ Та өөрөө, та өөрөө тэнд байсан, байсан шүү дээ.

.....
.....
.....

Өөрөө байсан, байсан байж, надаас асуугаад,” гэж хэллээ. Гэр дүүрэн, дүүрэн инээд, инээд болж, болж билээ.

.....
.....
.....

Дууссан:онсарөдөр